

**ТӨГСӨХ ДАМЖААНЫ РЕЗИДЕНТ ЭМЧ НАРЫГ АНУ, БНСУ-Д
ҮРГЭЛЖЛҮҮЛЭН СУРАЛЦАХ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРТ
ХАМРАГДАХЫГ УРЬЖ БАЙНА.**

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах чиг үүргийн хүрээнд олон улстай хамтарсан хөтөлбөрөөр төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаад байна.

Энэ хүрээнд АНУ, БНСУ-ын эрүүл мэндийн байгууллагад урт хугацааны сургалтын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдахыг урьж байна.

Сургалтын хугацаа: Сургалт 5-6 сар үргэлжилнэ. Сургалт 2025 оны 3-4 сард эхэлнэ.

Тавигдах шаардлага:

- Үндсэн мэргэшлийн төгсөх дамжааны оюутан байх;
 - Англи/ солонгос хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх /IELTS 6-аас дээш оноотой, TOPIK 4-өөс дээш оноотой/;
 - Өөрийн мэргэшсэн чиглэлээрээ суралцаж амжилт гаргах хүсэл эрмэлзэлтэй байх /Англи/солонгос хэл дээр 200 үгэнд багтаасан эсээ бичиж ирүүлэх/;
 - Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сан /www.hr.hdc.gov.mn/-д бүртгэлтэй байх;
- Холбогдох материалыг 2025 оны 02 дугаар сарын 18-ны 18:00 цаг хүртэл ariunzaya@hdc.gov.mn хаягаар хүлээн авна.

Жич: Улсын төсвийн санхүүжилтээр суралцагч нь давуу тал болно.

**БНСУ-Д УРТ ХУГАЦААНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАХЫГ УРЬЖ
БАЙНА.**

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-ын Эрүүл мэндийн байгууллагад урт хугацааны сургалтын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдахыг урьж байна.

Сургалтын чиглэл:

- Ерөнхий мэс засал – 1
- Эмэгтэйчүүд болон эх барих – 2

Сургалтын хугацаа: Сургалт 15 сар үргэлжлэх ба 2025 оны 3-4 сард сургалт эхэлнэ.

Тэтгэлэг: сургалтын төлбөр, дотуур байр, хоол, 2 талын нислэгийн тийз

Тавигдах шаардлага:

- Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад ажилладаг байх;
- Тухайн чиглэлээр үндсэн болон төрөлжсөн мэргэшил эзэмшсэн байх;
- Эзэмшсэн мэргэшлээрээ тухайн байгууллагадаа 3-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажилласан байх;
- Англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх;

- Өөрийн мэргэшсэн чиглэлээрээ суралцаж амжилт гаргах хүсэл эрмэлзэлтэй байх;
- Бүрдүүлэх материал
- CV буюу хувь хүний дэлгэрэнгүй тодорхойлолт /татаж авах/ /Одоо хэрэглэж буй утасны дугаарыг заавал оруулах/;
- Англи хэлний түвшин тогтоох шалгалтын оноо, гэрчилгээний хуулбар /БНСУ дахь эрүүл мэндийн байгууллагаас Англи хэлээр ярилцлага авна/;
- Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн санд / www.hr.hdc.gov.mn/ бүртгэлтэй байх;

Холбогдох материалыг 2025 оны 02 дугаар сарын 24-ний 18:00 цаг хүртэл ariunzaya@hdc.gov.mn хаягаар хүлээн авна.